



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2007 оны 06-р сарын 27-ны өдөр

Дугаар 82

Улаанбаатар хот

Аргачлал шинэчлэн батлах тухай

“Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 6.1.2 дахь заалт болон “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль”-ийн 19.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих аргачлал”-ыг хавсралт ёсоор баталж, 2007 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Энэхүү аргачлал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2003 оны 638 дугаар тушаалаар батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт хийх, үнэлгээ дүгнэлт хийх аргачлал”-ыг цаашид мөрдөхгүй байхаар тогтоож, энэ тухай Монголбанкинд мэдэгдсүгэй.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд сурталчилж ажиллахыг Ажлын алба /О.Ганбат/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАЙНААС ХЯНАЛТ ХИЙХ,
ҮНЭЛГЭЭ ДҮГНЭЛТ ӨГӨХ АРГАЧЛАЛ**

АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Хяналтын зорилго

ХОЁР. ХЯНАЛТ ТАВИХ

- 2.1 Хяналтын зарчим
- 2.2 Хяналтад ашиглах тайлан мэдээ
- 2.3 Тайлан мэдээг хянах
- 2.4 Хяналтын үйл ажиллагаа
- 2.5 ББСБ-ын санхүү, төлбөрийн чадварт үнэлэлт өгөх, эрсдэлийг тогтоох

ГУРАВ. ББСБ-ЫН ТҮҮХ ХӨТЛӨХ

ДӨРӨВ. ХЯНАЛТ ХИЙСЭН ТУХАЙ ДҮГНЭЛТ ТАНИЛЦУУЛГА

- 4.1 Зайнаас тавих хяналтын дүгнэлт бичих
- 4.2 Дүгнэлтийн хүрээ
- 4.3 Дүгнэлтийн бүтэц
- 4.4 Зайнаас тавьсан хяналтын дүгнэлт, танилцуулгад тавигдах шаардлагууд

ТАВ. ХЯНАЛТЫН МӨРӨӨР АВАХ АРГА ХЭМЖЭЭ

- 5.1 Тайлан мэдээнд тавих хяналтын мөрөөр авах арга хэмжээ
- 5.2 Албадлагын арга хэмжээ

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

ХАВСРАЛТ

- Хавсралт1 /Ашигт ажиллагаа/
- Хавсралт2 /Активын чанар/
- Хавсралт3 /Төлбөрийн чадвар/
- Хавсралт4 /Өөрийн хөрөнгө/
- Хавсралт5 /Гадаад валютын эрсдэл/
- Хавсралт6 /Зайнаас тавьсан хяналтын дүгнэлт/

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Хяналтын зорилго

1.1.1 “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 6.1.4 дэх заалтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо /цаашид Хороо гэх/-ноос банк бус санхүүгийн байгууллагын /цаашид ББСБ гэх/ үйл ажиллагаанд зайнаас хяналт хийх, үнэлгээ дүгнэлт өгөхөд /цаашид хяналт гэх/ энэхүү аргачлалыг мөрдлөг болгоно.

1.1.2 Зайнаас тавих хяналтын зорилго нь ББСБ-аас ирүүлсэн тайлан мэдээ, хөндлөнгийн хяналтын байгууллагаар хянуулсан тайлан, холбогдох бусад мэдээлэлд үндэслэн ББСБ-ын санхүү, төлбөрийн чадварын байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, үүсч болзошгүй эрсдэлийн түвшинг тогтоох, аливаа эрсдэлтэй асуудлыг илрүүлэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах буюу энэ талаарх саналаа Хорооны удирдлагад /цаашид удирдлага гэх/ танилцуулан холбогдох шийдвэр гаргуулахад оршино.

1.1.3 ББСБ-д тавих хяналтыг зайнаас болон дараалсан байдлаар хийнэ.

Үүнд:

1.1.3.1. Зайнаас тавих хяналтад дараах үйл ажиллагаа хамаарна:

а/ Санхүүгийн тайлан, бусад тайлан мэдээнд үндэслэн тухайн ББСБ-ын үйл ажиллагаанд оршиж байгаа болон цаашид үүсч болзошгүй эрсдэлийн түвшинг тогтоох, эрсдэлийг хариуцах хүрэлцээтэй өөрийн хөрөнгө байгаа эсэхийг хянах;

б/ ББСБ-ын үйл ажиллагаанд дахь эрсдэлийн түвшинг тогтоосны үндсэн дээр санхүү, төлбөрийн чадвар, үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт өгөх.

1.1.3.2. Дараалсан хяналтад дараах үйл ажиллагаа хамаарна:

а/ ББСБ-ын үйл ажиллагаа, санхүү төлбөрийн чадварыг нь сайжруулах чиглэлээр үүрэг даалгавар өгөх;

б/ Удирдлага, холбогдох ажилтнуудтай байнгын холбоотой ажиллах;

в/ Хорооны улсын байцаагч шаардлагатай гэж үзвэл газар дээр нь хэсэгчилсэн шалгалт хийх, холбогдох санал боловсруулах;

г/ Газар дээрх шалгалт хийхтэй холбогдуулан мэргэжилтэн нь хариуцсан ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг шалгалтын ажлын хэсэгт бэлтгэж өгөх, ББСБ-аас ирүүлсэн тайлан мэдээний үнэн зөв эсэхийг шалгалтын ажлын хэсгээр шалгуулах, зайлшгүй шалгах шаардлагатай асуудлын жагсаалт гаргаж өгөх;

д/ ББСБ-д өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг шалгаж, түүний мөрөөр арга хэмжээ авах буюу энэ талаар холбогдох саналаа Хорооны удирдлагад танилцуулж, шийдвэр гаргуулж ажиллана.

ХОЁР. ХЯНАЛТ ТАВИХ

2.1 Хяналтын зарчим

2.1.1 Мэргэжилтэн нь ББСБ-ын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавихдаа мөрдөгдөж буй хууль тогтоомж, Хорооноос баталсан заавар журам, олон улсын жишгийг үндэслэл болгоно.

2.1.2 Мэргэжилтэн нь ажил үүрэг гүйцэтгэж, хяналт тавихдаа бие даасан, шударга, ёс зүйн хэм хэмжээг чанд баримтлан ажиллана.

2.1.3 Мэргэжилтэн нь хариуцсан ББСБ-тай аливаа ашиг сонирхлын зөрчилгүй байна.

2.1.4 Мэргэжилтэн нь зайнаас болон дараалсан хяналтыг хийхдээ Хороонд мөрдөгдөж буй ажил үүргийн хуваарь, албан тушаалын зааврын дагуу ББСБ-ыг хариуцаж, түүний үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

2.2 Хяналтад ашиглах тайлан мэдээ

2.2.1 Мэргэжилтэн нь ББСБ-д хяналт тавихдаа тухайн ББСБ-ын тайлан, мэдээ, тэдгээрт хийсэн тайлбар болон Монголбанк, бусад этгээдүүдээс дараах, мэдээлэл /цаашид тайлан, мэдээ гэх/ авч ашиглана. Үүнд:

2.2.1.1. ББСБ-ын холбогдох заавар, журамд заагдсан тайлан, мэдээ, тайлбарын хамт;

2.2.1.2. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15.3 дугаар зүйлд заасны дагуу Хорооноос шаардсан бусад тайлан мэдээ;

2.2.1.3. Тухайн ББСБ-д хийсэн газар дээрх ээлжит, иж бүрэн болон хэсэгчилсэн, ээлжит бус шалгалтын акт материал, танилцуулга;

2.2.1.4. Тухайн ББСБ-ын санхүүгийн тайлан мэдээг хөндлөнгийн хяналтын байгууллагаас хянасан тухай тайлан, дүгнэлт, түүний тайлбар;

2.2.1.5. Дотоод хяналтын алба нэгжийн тайлан, мэдээ;

2.2.1.6. ББСБ анх байгуулагдахад бүрдүүлж ирүүлсэн баримт материал, түүнд орсон аливаа өөрчлөлтийн талаар тухай бүр ирүүлсэн мэдээлэл;

2.2.1.7. Монголбанкнаас авах дараах мэдээ материал. Үүнд:

а/ Зээлийн мэдээлэл /Зээлийн мэдээллийн сан/;

б/ Монголбанкны сар, жилийн статистик-бюллетень /Мөнгөний бодлого, судалгааны газар/;

в/ Гадаад валютын ханшийн мэдээ /Валютын газар/;

г/ Бусад шаардлагатай мэдээлэл.

2.2.1.8. Бусад мэдээлэл (ББСБ-ын харилцагчдын гомдол, ББСБ-ын үйл ажиллагаатай холбогдон аливаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээ, мэдээлэл, шүүх, хууль хяналтын байгууллагуудын ББСБ-тай холбогдон гаргасан шийдвэр, тогтоол болон бусад мэдээлэл г.м).

2.2.2 Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон ББСБ-аас хууль тогтоомжийн дагуу дараах тайлан мэдээ, судалгааг улирал бүрийн эцсийн өдрийн байдлаар гаргуулан авч, өгсөн үүргийн биелэлтийг тооцно. Үүнд:

а/ Гүйлгээ үлдэгдлийн хураангуй болон дэлгэрэнгүй тэнцэл, тэнцлийн гадуурх дансдын тайлан;

б/ Зээлийн өрийн үлдэгдлийн талаарх судалгаа /Татан буугдах үеийн байдлаар/;

в/ Бусад шаардлагатай мэдээлэл.

2.3 Тайлан мэдээг хянах

2.3.1 Мэргэжилтэн нь гагцхүү Хорооны бичиг хэрэгт бүртгэгдсэн тайлан, мэдээ, ББСБ-тай холбогдох бусад баримт, материалыг гарын үсэг зурж хүлээн авна.

2.3.2 Мэргэжилтэн нь хүлээн авсан тайлан мэдээг дор дурдсан байдлаар шалгана. Үүнд:

а/ тайлан мэдээ, бусад холбогдох мэдээллийг хууль тогтоомжид заасан хугацаанд ирүүлсэн эсэх;

б/ бүрэн гүйцэд эсэх;

в/ ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч болон холбогдох ажилтнууд санхүүгийн тайланг үнэн зөв гаргасан гэдгийг баталгаажуулан гарын үсгээ зурж, тамга, тэмдгээ дарсан эсэх;

г/ санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15.2 дугаар зүйлд заасны дагуу Хорооноос мөрдөгдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчимд нийцэж байгаа эсэх ;

д/ тайлан мэдээний үзүүлэлтүүдийг үнэ зөв гаргасан эсэх, тэдгээрийн уялдаа холбоо зөв эсэх;

е/ өмнөх тайланг үеийн тайлан мэдээн дэх үзүүлэлтээс өссөн болон буурсан үзүүлэлтүүдэд тайлбар хийсэн эсэх;

ё/ газар дээрх шалгалтын акт материалтай тохирч /зөрчил дутагдлыг арилгасан эсэх, активын ангилал ба активын эрсдэлийн санг бүрэн байгуулсан эсэх г.м/ байгаа эсэх.

2.3.3 Дээрх шаардлагын а/-д зааснаас бусад шаардлагыг хангаагүй тайлан мэдээг мэргэжилтэн хүлээн авахаас татгалзаж, шаардлага хангасан тайлан мэдээг яаралтай ирүүлэхийг тухайн ББСБ-аас шаардана.

2.3.4 Тайлан мэдээг бүрэн гүйцэд ирүүлээгүй ББСБ-д зөрчлийн байдлаас хамааруулан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомжийн дагуу холбогдох арга хэмжээг авна.

2.3.5 Татан буулгах ажлын хэсэг томилогдсон, тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон ББСБ-д тайлан мэдээ, судалгааг үндэслэн дараах байдлаар хяналт тавина. Үүнд:

а/ Зээлийн өрийн үлдэгдлийн талаарх судалгааг дэлгэрэнгүй тэнцэлтэй тулган шалгах,

б/ Шаардлагатай гэж үзвэл Шүүх, Шүүхийн шийдвэр биелүүлэх албанаас холбогдох судалгааг гаргуулж, харьцуулан хянах,

в/ Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн /зээл, итгэлцэл, хоёрдогч өглөг гэх мэт/ дебет гүйлгээг дэлгэрэнгүй тэнцэлтэй тулган шалгана.

2.4 Хяналтын үйл ажиллагаа

2.4.1 Зээлийн мэдээллийн санд ирүүлсэн зээлдэгчдийн үндсэн мэдээллийг газар дээрх шалгалтын зээлийн ангилалтай тохируулж, нийт зээлийн өрийн үлдэгдэл нь ангилал тус бүрээр ББСБ-ын тайлан тэнцлийн дүнтэй тохирч байгаа эсэхийг шалгана.

2.4.2 Санхүүгийн тайланд тохируулга хийхдээ ББСБ-д эрсдэл учруулж болзошгүй бүх үзүүлэлтүүдийг хянаж, удирдлагад урьдчилан танилцуулсны эцэст гүйлгээг хийлгэнэ.

2.4.3 Өөрийн хөрөнгө, нийт активын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын тайлан, гадаад валютын эрсдэлийн тайлан, зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээ, хангамжийн судалгааны тайлан, зээлийн төвлөрлийн эрсдэлийн тайлангууд болон бусад шаардлагатай тайланг гаргана.

2.4.4 Мэргэжилтний тооцож гаргасан тайлан мэдээ ББСБ-аас ирүүлсэн тайлан мэдээтэй тохироогүй тохиолдолд мэргэжилтэн өөрийн гаргасан тайлан

мэдээ тус бүрт зөрүүний талаар дэлгэрэнгүй тайлбар хийж, хэрэв ББСБ алдаа гаргасан бол тэр тухай тайлангийн хариунд тусгаж, дүгнэлтэндээ тодорхой бичиж гарын үсгээр баталгаажуулсан байна.

2.4.5 Мэргэжилтэн ББСБ-ын үйл ажиллагаанд хяналт тавихдаа тухайн ББСБ-ын үзүүлэлтүүдийг авч үзэхээс гадна үйл ажиллагаа явуулах хэлбэр, цар хүрээний хувьд ижил төстэй бусад ББСБ-ын дундаж, үзүүлэлтүүдтэй харьцуулан авч үзнэ.

2.4.6 Бусад.

2.5 ББСБ-ын санхүү төлбөрийн чадварт үнэлэлт өгөх, эрсдэлийг тооцох

2.5.1 Мэргэжилтэн зайнаас хяналт тавихдаа тухайн ББСБ-д үүсч болзошгүй аливаа эрсдэлтэй асуудлыг илрүүлэн, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, ирүүлсэн тайлан мэдээ, холбогдох бусад мэдээлэлд үндэслэн ББСБ-ын санхүү, төлбөрийн чадварын байдалд үнэлэлт дүгнэлт өгч, Хорооноос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тооцно.

2.5.2 ББСБ-ын тайлан тэнцэл, бусад тайлан мэдээг компьютерт шивж, түүнд суулгасан файлын дагуу мэдээллийн товчоо, санхүүгийн үзүүлэлтүүдийн динамик судалгааг гаргаж, тухайн ББСБ-ын хувийн хэрэгт хадгална.

2.5.3 Дээрх файлын дагуу ББСБ-ын тайлан тэнцэл, актив, пассивын болон бусад шаардлагатай үзүүлэлтүүдийн өмнөх үеэс өөрчлөгдсөн байдал, санхүү, төлбөрийн чадвар болон бусад үзүүлэлтийн харьцаануудыг Хавсралт 1-5-ыг ашиглан тооцоолж, үнэлгээ, дүгнэлт өгнө. Үүнд:

2.5.3.1. **Ашигт ажиллагаа:** ББСБ-ын үйл ажиллагааны ерөнхий хандлага, удирдлагын чадварыг тодорхойлох зорилгоор мэргэжилтэн ББСБ-ын ашигт ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллана. Ашигт ажиллагаатай холбогдох үзүүлэлтүүдийг Хавсралт 1-ийн дагуу улирал бүр тооцож динамик судалгааг хөтөлнө.

2.5.3.2. **Активын чанар:** ББСБ нь активаа зөв зохистой байршуулах нь активаас үүсэх аливаа эрсдэлийг бууруулж, улмаар ашигт ажиллагааг нэмэгдүүлэх тул ББСБ-ын активын чанарыг тогтоосон журмын дагуу улирал бүр тооцож, зайнаас тавих хяналтын дүгнэлтэд оруулж, динамик судалгааг хөтөлнө.

2.5.3.3. **Төлбөрийн чадвар:** ББСБ активаа орлого оруулдаг активт байршуулж буй эсэх, хүлээсэн үүргээ биелүүлэх тодорхой хэмжээний эх үүсвэрийг мөнгөн хөрөнгийн хэлбэрээр байршуулсан эсэхийг хянах зорилгоор ББСБ-ын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийн байдлыг "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоох тухай журам" болон Хавсралт 3-ын дагуу улирал бүр үнэлгээ, дүгнэлт гарган, динамик судалгаа хөтөлнө.

2.5.3.4. **Өөрийн хөрөнгийн хүрэлцээ:** ББСБ-ын өөрийн хөрөнгийн хэмжээ нь эрсдэл хүлээх чадварыг илэрхийлэх тул хариуцсан ББСБ-ын өөрийн хөрөнгийн хэмжээ хангалттай түвшинд байгаа эсэхийг ББСБ-ын ашигт ажиллагаатай холбон өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтээр энэ аргачлалын Хавсралт 4 болон "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоох тухай журам"-ын дагуу тооцож үнэлэлт, дүгнэлт өгнө.

2.5.3.5. *Гадаад валютын эрсдэл:* Валютын ханшийн өөрчлөлтөөс үүсэх эрсдэлийг тодорхойлж, түүнээс сэргийлэх зорилгоор гадаад валютын эрсдэлийн шинжилгээг холбогдох журмын дагуу хийж, энэхүү аргачлалын хавсралт 5-ын дагуу үнэлэлт дүгнэлт өгнө.

2.5.3.6. *ББСБ-ын удирдлага:* ББСБ-ын санхүү, төлбөрийн чадварын байдал нь удирдлагын гаргаж байгаа аливаа шийдвэрээс хамаарах тул удирдлагын туршлага, боловсролын түвшин болон бусад тодорхойлолтод үндэслэн үнэлэлт өгнө.

2.5.4 Мэргэжилтэн хариуцсан ББСБ-ын санхүүгийн тайланд үндэслэн гаргасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлангийн холбогдох үзүүлэлтүүдэд үнэлгээ дүгнэлт өгнө. Хариуцсан ББСБ-ын үйл ажиллагаан дахь эрсдэлийг тооцох, түүний зах зээлийн өөрчлөлтийн мэдрэмжийг тодорхойлох үүднээс төрөл бүрийн шинжилгээний аргууд/Stress test, Z-score, Gap analysis/-ыг хэрэглэж, дүгнэлт гаргана.

2.5.5 Гадаад дотоодын үнэт цаас, хувьцаа эзэмшиж байгаа нөхцөлд зах зээлийн эрсдэлийн шинжилгээ болон зээлийн эрсдэлийн шинжилгээг хийнэ.

2.5.6 Мэргэжилтэн нь тохируулга хийсэн гүйлгээ үлдэгдлийн хураангуй тэнцэл, бусад тайлан мэдээнд үндэслэн улирал бүр зайнаас тавьсан хяналтын дүгнэлт /цаашид дүгнэлт гэх/ бичиж, холбогдох арга хэмжээг хууль тогтоомжоор олгогдсон эрхийнхээ хүрээнд цаг алдалгүй авч хэрэгжүүлнэ. Зайлшгүй шаардлага /гэнэтийн шалгалт хийгдэх, үйл ажиллагаа нь илт доголдох, удирдлагаас мэдээлэл шаардах/ гарсан бол тухайн сараар зайнаас тавьсан хяналтын дүгнэлт бичиж болно.

2.5.7 ББСБ хариуцсан мэргэжилтэн нь зайнаас тавих хяналтын дүгнэлтээс гадна "Банк бус санхүүгийн байгууллагын хувийн хэргийг хөтлөх заавар"-ын дагуу мэдээллийг хагас жил тутам гаргаж хувийн хэрэгт хадгална.

2.5.8 ББСБ-ын тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон үед татан буулгах үйл ажиллагаа, хууль тогтоомжийн дагуу ямар арга хэмжээ авагдсан талаар мэргэжилтэн танилцуулга бичиж, Хорооны удирдлагад танилцуулна.

2.5.9 Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгож байгаа тохиолдолд Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх тогтоолын төсөл бэлтгэж, удирдлагад танилцуулан холбогдох шийдвэр гаргуулан хүргүүлэх, зөвшөөрөл татсанаас хойш хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөөг ББСБ-аас гаргуулан авч, уг үйл ажиллагаанд хяналт тавьж, зөвшөөрлийн гэрчилгээг хүчингүй /гэрчилгээг хураан авч хавсралтын хамт "Хорооны ...оны ...тоот тогтоолоор хүчингүй" гэсэн тэмдэгийг баруун доод өнцөгт 45 градусын налуугаар дарж ББСБ-ын хувийн хэрэгт хадгална/ болгоно.

ГУРАВ. ББСБ-ЫН ТҮҮХ ХӨТЛӨХ

3.1 ББСБ-ын түүх /цаашид түүх гэх/-д ББСБ үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авснаас хойш татан буугдах хүртэлх хугацааны тухайн ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цаг хугацааны дарааллын дагуу бичиж хадгална.

3.2 ББСБ хариуцсан мэргэжилтэн түүхийг улирлын үечлэлтэйгээр хөтөлнө. Түүх нь дараахь 4 үндсэн хэсгээс байна. Үүнд:

а/ Үндсэн мэдээлэл,

б/ Динамик үзүүлэлтүүд

в/ ББСБ-д Хороо болон бусад холбогдох байгууллагаас /Гааль, Татвар, Санхүү Эдийн Засгийн Яам гэх мэт/ авсан арга хэмжээний жагсаалт

г/ ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой онцлог түүх.

3.2.1. Үндсэн мэдээлэлд тухайн ББСБ үүсгэн байгуулагдсан, татан буугдсан огноо, удирдлага, бүтэц зохион байгуулалт гэх зэрэг ББСБ-ын талаарх мэдээллүүдийг тусгана. Үүнд:

- Товч мэдээлэл,
- Дүрмийн сангийн хувь хэмжээ, бүтцийн талаарх мэдээлэл,
- Салбар, нэгжийн талаарх мэдээлэл,
- Бусад.

3.2.2. ББСБ-ын талаарх товч мэдээллийг Хавсралт 9, ББСБ-ын дүрмийн сангийн талаарх мэдээллийг Хавсралт 10, салбар нэгжийн талаарх мэдээллийг Хавсралт 11-ын дагуу гаргана.

3.3 Динамик үзүүлэлтүүдэд Хорооноос ББСБ-д тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд болон бусад санхүүгийн үзүүлэлтүүдийг цаг хугацааны дарааллын дагуу тусгана. Уг үзүүлэлтүүдийг Хавсралт 7, Хавсралт 8-ын дагуу гаргана.

3.4 ББСБ-д Хороо болон бусад холбогдох байгууллагаас авсан арга хэмжээний жагсаалтыг Хорооноос авсан арга хэмжээ, холбогдох бусад байгууллагаас авсан арга хэмжээ гэж 2 хэсэгт ангилж бичнэ. Хорооноос авсан арга хэмжээг албадлагын арга хэмжээ, бусад арга хэмжээ гэж 2 хэсэгт хуваана.

3.4.1. Хорооноос авсан албадлагын арга хэмжээнд улсын байцаагчийн тогтоосон акт, мэдэгдэл, шийтгэвэр, хугацаат үүрэг даалгавар өгөх тухай албан тоот бичиг, Хорооны тогтоол, шийдвэр зэрэг орно.

3.4.2. Бусад арга хэмжээнд тус ББСБ-д Хорооноос явуулсан бусад албан тоот, тогтоол, шийдвэр орно.

3.4.3. Холбогдох бусад байгууллагаас авсан арга хэмжээний жагсаалтыг тухайн байгууллагуудаас ББСБ-тай холбогдуулан Хороонд ирүүлсэн баримт бичгийг үндэслэж гаргана. ББСБ-д Хороо болон бусад холбогдох байгууллагаас авсан арга хэмжээний жагсаалтыг Хавсралт 12-ын дагуу гаргана.

3.5 ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой онцлог түүх гэж тухайн ББСБ-тай холбоотой гарсан онцгой мэдээллүүдийг хэлэх бөгөөд /ББСБ-ын удирдлага, ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орох гэх мэт/ түүнийг Хавсралт 13-ын дагуу гаргана.

3.6 ББСБ хариуцсан мэргэжилтэн нь жилд 1 удаа дараа жилийн 2 дугаар сарын 25-ны өдрийн дотор ББСБ-ын түүхийг газрын даргад танилцуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд тухай бүрд нь танилцуулна.

3.7 ББСБ хариуцсан мэргэжилтэн нь түүх агуулсан файлыг өөрийн эзэмшиж буй компьютерт нууц код өгч хадгална. Мэргэжилтэн түүх агуулсан файлыг ББСБ-ын нэгтгэл хариуцсан мэргэжилтэнд жилд нэг удаа 2 сарын 10-ны өдрийн дотор дотоод сүлжээгээр дамжуулан өгнө.

3.8 ББСБ-ын нэгтгэл хариуцсан мэргэжилтэн ББСБ-ын түүх агуулсан файлыг жилд нэг удаа архивлан хадгална. ББСБ-ын түүх нь нууцын ангилалд хамаарах бөгөөд үүнтэй холбоотой харилцааг холбогдох журмаар зохицуулна.

ДӨРӨВ. ХЯНАЛТ ХИЙСЭН ТУХАЙ ДҮГНЭЛТ, ТАНИЛЦУУЛГА

4.1 Зайнаас тавих хяналтын дүгнэлт бичих

4.1.1 Мэргэжилтэн ББСБ-ын үйл ажиллагаа, санхүү төлбөрийн чадварт зайнаас тавьсан хяналтын талаарх дүгнэлт, танилцуулгыг дараах зарчим, шаардлагыг баримтлан бичнэ. Үүнд:

4.1.1.1. Мэргэжилтэн дүгнэлтийг бичихдээ ББСБ-ын санхүү, төлбөрийн чадварын байдал, эрсдэлийн түвшинг бүрэн гүйцэд илэрхийлсэн, ойлгомжтой, товч тодорхой байх зарчмыг баримтална.

4.1.1.2. Дүгнэлт нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

а/ Энэхүү аргачлалд заасан бүтцийн дагуу бичигдсэн байх;

б/ ББСБ-ын үйл ажиллагааны тухай дүгнэлтийг товч бөгөөд бүрэн гүйцэд, үнэн зөв бичсэн байх;

в/ ББСБ-ын эрсдэлийг тодорхойлж, ойрын ирээдүйд санхүү, төлбөрийн чадварын хүндрэлд орж болзошгүй эсэхийг тогтоосон байх;

г/ Хяналтын хүрээнд Хорооны даргын тушаал болон өгсөн бусад үүрэг/цаашид үүрэг гэх/-ийн биелэлтийг гаргасан байна. Үүнд:

- Хэрэв үүргийн биелэлтийг хяналтын хүрээнд биелсэн гэж үзэх боломжтой бол энэ тухайгаа бичих;

- Үүргийн биелэлтийг хяналтын хүрээнд дүгнэх боломжгүй гэж үзвэл холбогдох арга хэмжээ авах тухай саналаа тодорхой тусгах.

4.1.2 ББСБ-ын санхүү, төлбөрийн чадварыг илэрхийлсэн аливаа үзүүлэлтийн өөрчлөлтийн талаар дүгнэлтэд тодорхой тусгана.

4.2 Дүгнэлтийн хүрээ

4.2.1 Дүгнэлтийг улирал, жилийн үйл ажиллагааг хамарсан байдлаар бичнэ. Мөн газар дээрх шалгалт хийхтэй холбогдуулан тухайн ББСБ-ын үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварын үзүүлэлтээр тусад нь дүгнэлт бичнэ.

4.2.2 ББСБ-ын үйл ажиллагаанд хийсэн хяналтын болон газар дээрх шалгалт хийхэд зориулан бичих дүгнэлтийг зайнаас хяналт тавих дүгнэлтийн нэгэн адил 6 дугаар хавсралтын дагуу бичих бөгөөд шаардлагатай зүйлийг нэмж бичиж болно.

4.2.3 ББСБ-ын зайны дүгнэлтийг бичихдээ энэхүү аргачлалын 1-11 дүгээр хавсралтыг ашиглан тухайн жил, улирлын үйл ажиллагааг хамруулан холбогдох үзүүлэлтүүдийг тооцож, өмнөх улирал, тайлант оны эхэн болон өмнөх оны мөн үеэс өөрчлөгдсөн байдал, түүний шалтгааны талаар тусгаж, зохистой харьцааны

биелэлтийг тусгасан байна. Дүгнэлтэд ББСБ-ын санхүү, төлбөрийн чадварын болон бусад холбогдох үзүүлэлтийн динамик судалгааг графикаар гарган хавсаргана.

4.2.4 ББСБ-ын санхүү төлбөрийн чадварын талаарх дүгнэлтийг бичихдээ бусад ББСБ-тай харьцуулан дүгнэлт хийж болно.

4.2.5 Тайлант хугацаанд ББСБ-ын үйл ажиллагааны үзүүлэлтүүдэд огцом өөрчлөлт гараагүй бол уг үзүүлэлтийн талаар дүгнэлтэд дурдахгүй байж болно.

4.3 Дүгнэлтийн бүтэц

4.3.1 ББСБ-ын системийн санхүү, төлбөрийн чадварын тухай дүгнэлтийг дараах бүтэцтэйгээр бичиж, удирдлагад танилцуулна.

Нэг. Оршил (ББСБ-ын үндсэн үзүүлэлтүүдийн хураангуй)

Хоёр. ББСБ-ын үйл ажиллагаа, төлбөрийн чадварын талаарх дүгнэлт

Гурав. Тухайн ББСБ-д хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал

Дөрөв. Ашигт ажиллагааны талаар

Тав. Өөрийн хөрөнгийн талаар

Зургаа. Активын чанар, Чанаргүй зээлийн талаар

Долоо. Төлбөрийн чадвар, Пассивын бүтэц

Найм. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хангалт

Ес. Удирдлага, бүтэц зохион байгуулалт, ББСБ-ын үйл ажиллагаанд гарсан өөрчлөлтүүд

Арван нэг. ББСБ-д авч хэрэгжүүлсэн арга хэмжээний товч танилцуулга

Арван хоёр. Хавсралт материал

4.3.2 Системийн нэгтгэл хариуцсан мэргэжилтэн ББСБ-ын тайлан мэдээг тайлант хугацааны дараа сарын 20-ны өдрийн дотор дотоод сүлжээгээр татан авч, ББСБ-ын системийн санхүү, төлбөрийн чадварын болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн тайланг нэгтгэнэ.

4.3.2.1. ББСБ-ын системийн үндсэн үзүүлэлтийн хураангуйд ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, тэдгээртэй холбоотой санхүүгийн үзүүлэлтүүдийг системийн хэмжээгээр болон бүлгийн дунджаар гаргаж холбогдох тайлбар, дүгнэлт хийнэ. Ингэхдээ ББСБ-ын тайлан тэнцэлд ямар тохируулга хийсэн тухай тодруулга, тайлбарыг ББСБ-ын хариуцсан мэргэжилтнээс гаргуулан тус бүрд нь тодорхой тайлбарлаж, дараах үзүүлэлтүүдийн талаар он дараалсан судалгаа хийж, график дүрслэлийг танилцуулгад хавсаргана. Үүнд:

а/ ББСБ-ын системийн ерөнхий үзүүлэлтүүд;

б/ Актив, пассивын бүтэц, холбогдох харьцаанууд;

в/ Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт;

г/ Ашигт ажиллагааны үзүүлэлтүүд;

д/ Эрсдэлийн үзүүлэлтүүд;

е/Хорооны тогтоолоор батлагдсан заавар, журмын дагуу тооцох үзүүлэлтүүд болон ББСБ-ын системийн санхүүгийн байдлыг илтгэх шаардлагатай бусад үзүүлэлтүүдийг оруулна.

4.3.2.2. Системийн нэгтгэл хариуцсан мэргэжилтэн нь зайнаас тавьсан хяналтын дүгнэлттэй танилцан, газрын даргын саналыг авсны үндсэн дээр

зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хувьд зөрчилтэй, санхүү төлбөрийн чадвар нь муудах хандлагатай, эрсдэл нь нэмэгдэж байгаа болон онцгой анхаарал татсан ББСБ-ын талаар дараах байдлаар танилцуулга, дүгнэлтийг бичнэ.

а/ Тайлант хугацаанд гарсан өөрчлөлт;

- Бүтэц зохион байгуулалт,

- Санхүү, төлбөрийн чадварын талаар,

б/ ББСБ-ын санхүүгийн системд үзүүлэх нөлөөлөл, цаашдын хандлага.

4.3.2.3. Дээрх дүгнэлтийг үндэслэн газрын дарга ББСБ-ын санхүү төлбөрийн чадвар, авах арга хэмжээний тухай санал, анхаарал татсан, түдгэлзүүлсэн ББСБ-ын талаар танилцуулгыг Ажлын албанд танилцуулна.

4.3.3 Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон, татан буулгах ажлын хэсэг томилогдсон ББСБ-ын талаар дүгнэлт, танилцуулгыг дараах байдлаар хийнэ. Үүнд:

а/ Бусад байгууллага, иргэдтэй хийх өглөг, авлагын тооцоог барагдуулж байгаа байдал;

б/ Холбогдох байгууллага, иргэдийн санал, хүсэлт, өргөдөл гомдлын дагуу Хорооны зүгээс авсан арга хэмжээ;

в/ Шаардлагатай гэж үзвэл цаашид авах арга хэмжээний талаарх санал.

4.3.3.1 Дараах тохиолдлуудад банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон, татан буулгах ажлын хэсэг томилогдсон ББСБ-д хяналт тавих үйл ажиллагаа дуусгавар болно. Үүнд:

а/ Зөвшөөрөл нь хүчингүй болсон ББСБ-ын татан буулгах үйл ажиллагаа дууссан;

б/ ББСБ-ын санхүүгийн үзүүлэлтүүдийг системийн нэгдсэн үзүүлэлтүүдээс хасах тухай шийдвэр болон хяналт тавихыг зогсоох тухай шийдвэр гарсан.

4.3.4 Зөвшөөрөл нь хүчингүй болсон ББСБ-д хяналт тавих үйл ажиллагаа дуусгавар болсон тохиолдолд хувийн хэргийг "Банк бус санхүүгийн байгууллагын хувийн хэргийг хөтлөх заавар", холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу Хорооны архивт шилжүүлнэ.

4.4 Зайнаас тавьсан хяналтын дүгнэлт танилцуулгад тавигдах шаардлагууд

4.4.1 Мэргэжилтэн нь өөрийн гарын үсэг, хэрэв улсын байцаагч бол гарын үсэг болон хувийн дугаар бүхий тэмдгээр баталгаажуулсан зайнаас тавьсан хяналтын дүгнэлтийг, тохируулга хийсэн тэнцэл, орлого зарлагын тайлан бусад хавсралтын хамт улирал бүрийн дараа сарын 20-ны өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор газрын даргад танилцуулна.

4.4.2 Газрын дарга нь энэхүү аргачлалд заасны дагуу дүгнэлт бичигдсэн эсэхийг хянаж, энэ аргачлалын дагуу бичигдээгүй, дутуу бичигдсэн болон дэлгэрүүлэн нэмж тодруулах зүйлсийг тодруулах талаар мэргэжилтэнд мэдэгдсэний үндсэн дээр санал дүгнэлтийг ажлын 3 хоногийн дотор мэргэжилтэнд буцаан өгнө.

4.4.3 Газрын дарга нь дүгнэлтийг шаардлага хангасан гэж үзвэл хянасан тухайгаа баталгаажуулан гарын үсэг зурж, ББСБ-ын үзүүлэлтүүдийг системийн нэгтгэлд нэгтгүүлсэн эсэхэд хяналт тавина.

4.4.4 Мэргэжилтэн нь газрын даргад танилцуулсан дүгнэлтийн нэг хувийг тухайн ББСБ-ын хувийн хэргийн холбогдох хавтсанд хадгална.

4.4.5 Мэргэжилтэн нь ББСБ-ын санхүү, төлбөрийн чадварын байдалд хяналт тавихаас гадна хариуцсан ББСБ болон түүнтэй холбогдох байгууллага иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч хариуцсан мэргэжилтэн, улсын байцаагчийн эрхийн хүрээнд холбогдох хууль тогтоомж, заавар журмын дагуу шийдвэрлэх саналаа боловсруулж газрын даргад тухай бүрд нь танилцуулж байна.

4.4.6 Мэргэжилтэн нь ББСБ-аас улирал бүрийн эцсийн өдрийн байдлаар ирүүлсэн тайлан мэдээг хянаж, тайлангийн хариуг ББСБ-ын эрхэлж буй үйл ажиллагааны төрлөөс нь хамаарч хавсралт 7, 8-ын дагуу боловсруулахдаа тайлангийн хариуг дэлгэрэнгүй бичиж болох ба тайлант хугацааны дараа сарын 20-ны өдрийн дотор явуулна.

4.4.7 ББСБ-ын системийн нэгтгэл хариуцсан мэргэжилтэн системийн нэгдсэн танилцуулгыг улирал бүрийн дараа сарын 25-ны дотор бэлэн болгож, газрын даргад танилцуулна.

4.4.8 Газрын дарга нь системийн нэгтгэл хариуцсан мэргэжилтний боловсруулсан системийн нэгтгэл, нэгдсэн танилцуулгыг хянасны дагуу гарын үсэг зурж баталгаажуулна.

4.4.9 ББСБ-ын улирал бүрийн системийн нэгтгэлийг танилцуулгын хамт Хорооны гишүүд, бусад газарт улирал бүрийн дараа сард багтаан хүргүүлж, мэдээллээр хангаж ажиллана.

4.4.10 ББСБ-ын зайны хяналтыг хэрэгжүүлэхдээ ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээллийг шаардлагатай тохиолдолд Хорооны гишүүд, бусад газарт тухай бүр танилцуулна.

4.4.11 ББСБ-ын системийн нэгтгэлийг тайлант хугацааны дараа улирлын дунд сарын 15-ны өдрийн дотор УИХ, Сангийн яам, Монголбанк, Азийн хөгжлийн банкны Монгол улс дахь суурин төлөөлөгчийн газарт санхүүгийн тайлангийн хамт хүргүүлнэ.

ТАВ. ХЯНАЛТЫН МӨРӨӨР АВАХ АРГА ХЭМЖЭЭ

5.1 Тайлан мэдээнд тавих хяналтын мөрөөр авах арга хэмжээ

5.1.1 ББСБ-аас ирүүлсэн тайлан мэдээ нь хууль тогтоомжид заасан шаардлага хангаагүй буюу ББСБ цаг хугацаанд нь тайлан мэдээгээ ирүүлээгүй бол ББСБ хариуцсан мэргэжилтэн дараах арга хэмжээг шат дараалан авна.

5.1.1.1. Тайлан мэдээг ирүүлэх тогтоосон хугацаанаас хойш ажлын нэг хоногоор хоцорсон бол тэр даруй Хорооны бичиг хэргээс тухайн тайлан мэдээг шүүн шалгаж тодруулна.

5.1.1.2. Тайлан мэдээг ирүүлээгүй нь тогтоогдвол ББСБ-ын удирдлагуудад улсын байцаагчийн мэдэгдлээр яаралтай мэдэгдэж, нэн даруй ирүүлэхийг шаардана.

5.1.1.3. Тайлан мэдээг цаг хугацаанд нь ирүүлээгүй зөрчлийг давтан гаргасан буюу улсын байцаагчийн мэдэгдлээр тогтоосон хугацаанд ирүүлээгүй тохиолдолд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн дагуу холбогдох арга хэмжээ авна.

5.1.1.4. Дээрх зөрчлийг давтан гаргасан, шаардсаар байтал тайлан мэдээг ирүүлээгүй тохиолдолд улсын байцаагчийн акт тогтоон дараагийн шатны арга хэмжээг авч, Ажлын албанд танилцуулна.

5.1.1.5. Хэрэв ББСБ хууль тогтоомжид зааснаас өөрөөр эсвэл тэдгээрт заасан шаардлагыг хангаагүй тайлан мэдээ ирүүлсэн бол улсын байцаагчийн мэдэгдлээр тухайн ББСБ-ын удирдлагад мэдэгдэж, шаардлага хангасан тайлан мэдээг нэн даруй ирүүлэхийг шаардана.

5.1.1.6. ББСБ-ын санхүүгийн тайлан, бусад тайлан мэдээг алдаатай, холбогдох хууль тогтоомжийн дагуу гаргаж ирүүлээгүй зөрчлийг давтан гаргасан бол ББСБ-ын захиралд танилцуулж, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн дагуу холбогдох арга хэмжээг шат дараалан авна.

5.2 Албадлагын арга хэмжээ авах

5.2.1 Хууль тогтоомж болон Хорооны бүрэн эрхэд хамаарах асуудлаар гаргасан аливаа шийдвэрийг зөрчсөн бол тухайн зөрчлийн шинж байдлыг харгалзан, Хорооны улсын байцаагч захиргааны шийтгэл ногдуулахад мөрдөх холбогдох журмын дагуу Хорооны албадлагын арга хэмжээ авч, захиргааны шийтгэл ногдуулна. ББСБ-д арга хэмжээ авч, захиргааны шийтгэл ногдуулахаас гадна дараах арга хэмжээний аль тохирохыг авч хэрэгжүүлж болно. Үүнд:

1. ББСБ-ын удирдлагатай уулзалт хийх;
2. Газар дээр шалгалт хийх;
3. Үүрэг даалгавар өгөх
4. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 20-р зүйлийн дагуу арга хэмжээ авах.

5.2.2 ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллаагүй зөрчлийг эхний удаа гаргасан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авахыг сануулж, улсын байцаагчийн мэдэгдэл явуулна.

5.2.3 ББСБ-ын гаргасан зөрчил дутагдал нь ноцтой буюу өмнөх зөрчил дутагдлыг дахин давтсан, энэ нь тухайн ББСБ-ын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй гэж хариуцсан мэргэжилтэн үзвэл тухайн ББСБ-ын талаар газрын даргаар дамжуулан Хорооны даргад танилцуулга бичиж, урьдчилсан хяналтын дүгнэлтийг хавсаргана. Танилцуулгад дараах асуудлуудын талаар тодорхой тусгасан байна. Үүнд:

- а/ Тухайн зөрчил нь хууль тогтоомжийг ямар хугацаагаар, хэдэн удаа зөрчсөн;
- б/ Уг зөрчилтэй холбогдуулан ББСБ хариуцсан мэргэжилтнээс авсан арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй жагсаалт;
- в/ Тухайн зөрчил, дутагдлыг гаргаснаар тухайн ББСБ-ын санхүү төлбөрийн чадварт хэрхэн нөлөөлсөн, цаашид ямар байдлаар нөлөөлөх;
- г/ Зөрчлийг арилгах арга хэмжээний талаар ББСБ-ын хариуцсан мэргэжилтний санал.

5.2.4 Зөрчлийг арилгах арга хэмжээний саналд ББСБ-ын тодорхой үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх, хязгаарлах, зогсоох эсхүл Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 20-р зүйлийн дагуу арга хэмжээ авах талаар тусгана.

5.2.5 Мэргэжилтэн нь санхүү, төлбөрийн чадварын хүндрэлд орсон ББСБ-д албадлагын арга хэмжээ авах шаардлагатай гэж үзвэл холбогдох акт, албан тоот, тушаалын төслүүдийг дүгнэлтийн хамт Газрын даргад танилцуулна.

5.2.6 Газрын дарга танилцуулгыг хянаж, өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдэх боломжтой гэж үзвэл холбогдох арга хэмжээг авна. Хэрэв боломжгүй болон үүссэн асуудлыг ноцтой гэж үзсэн тохиолдолд нэмж тодруулах шаардлагатай зүйлсийг тодруулж Ажлын албаны даргад танилцуулна.

5.2.7 Ажлын албаны дарга танилцуулгатай танилцаж өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдэх боломжтой гэж үзвэл холбогдох арга хэмжээг авна. Хэрэв боломжгүй болон асуудлыг ноцтой гэж үзсэн тохиолдолд Хорооны дарга, Хорооны гишүүдэд танилцуулсны үндсэн дээр шаардлагатай гэж үзвэл Хорооны хуралдаанаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулна.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

